

ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХҮНЛЭГ БУС ХАРЬЦААНААС

АНГИД БАЙХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

- 1. UPR II циклээс хүлээж авсан зөвлөмж, хэрэгжилт:** Монгол Улс UPR II циклээс эрүүдэн шүүх, бусад хүнлэг бус харьцаанаас ангид байх хүрээнд нийт 20 зөвлөмж хүлээж авсан. Үүнээс ЭШЭК-ийн хувь хүний, улс хоорондын гомдол мэдээллийн журмыг хүлээн зөвшөөрөх мэдэгдэл хүргүүлэх зөвлөмжийн хүрээнд тодорхой алхам хийгдээгүй байна. Бусад зөвлөмжийн хүрээнд хэрэгжилт хэр байгааг тус бүрд нь авч үзлээ.
- 2. “Эрүүдэн шүүх” гэмт хэргийг ЭШЭК-д нийцүүлэх:** “Эрүүдэн шүүх” үйлдлийг 2015 оны Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд тусгахдаа ЭШЭК-ийн 1-р зүйлийн тодорхойлолтод нийцүүлэн томъёолсон хэдий ч хүлээлгэх ял шийтгэл нь тус гэмт хэргийн “онц хүнд” шинжид бүрэн нийцээгүй. Мөн “эрүүдэн шүүх” үйлдлийг өөр 4 төрлийн гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлд оруулсан нь гэмт хэргийн зүйлчлэлд тодорхойгүй байдлыг үүсгэхээр байна. Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар “бусад хүнлэг бус харьцаа”-г хориглосон ч энэ үйлдлийг гэмт хэрэгт тооцоогүй.
- 3. Хохирол барагдуулах:** Эрүүдэн шүүгдсэний улмаас буй болдог сэтгэл санааны хохирлыг барагдуулах асуудлыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд 45 дугаар зүйлд маш ерөнхий зааж, Иргэний хуульд заасан журмыг баримтлахаар тогтоожээ.ⁱ Хэдийгээр хохирлоо барагдуулах эрхийг баталгаажуулсан ч сэтгэл санааны хохирлыг хэрхэн тогтоох, үнэлэх асуудлыг зохицуулаагүй, мөн Эрүүгийн хуулиар “эрүүдэн шүүгдсэний” улмаас бий болох сэтгэл санааны хохирлыг тодорхой заагаагүй. Тиймээс шүүх зөвхөн бодит хохирлыг нөхөн төлдөг практик тогтоод байна.
- 4. Хараат бус мөрдөн шалгах алба:** Эрүүдэн шүүсэн тохиолдлыг хараат бусаар мөрдөн шалгах албыг УЕПГ-ын дэргэд 2002 онд байгуулан ажиллуулж байсныг 2014 оны 1-р сард онд татан буулгасан. УЕПГ-ын дэргэдэх Мөрдөн байцаах алба татан буугдсанаас хойш эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгах, илрүүлэх үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байгаа болохыг ХЭҮК-ын Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18-р илтгэлд тодорхой тоо баримтаар дүгнэсэн.ⁱⁱ Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн мэдээгээр 2017, 2018 онд эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хянан шийдвэрлээгүй байна.ⁱⁱⁱ Гэвч Хууль зүй дотоод хэргийн сайд Ц.Нямдорж хэвлэл мэдээллийн хэрэгслээр Монгол Улсад эрүүдэн шүүлт бодитой явагдсан гэдгийг албан ёсоор хүлээгээд байгаа билээ.^{iv}
- 5. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх нь:** Монгол улс 2014 оны 12 дугаар сарын 11-нд ЭШЭК-ийн Нэмэлт протоколыг соёрхон баталсан ч Урьдчилсан сэргийлэх үндэсний механизм (УСҮМ) байгуулах үүргээ өнөөг хүртэл биелүүлээгүй байна. Ингэснээр хорих, цагдан хорих газарт гарч буй эрүү шүүлт, зүй бус харьцааг нуун далдлах, эрүүдэн шүүхээс ангид байх эрх зөрчигдөхөд хүргэж байна. УСҮМ-ыг ХЭҮК-ын дэргэд байгуулах бодлогын шийдэлд хүрч, 2018 онд ХЗДХЯ-ны дэргэд ХЭҮК-ын тухай хуулийг шинэчлэн найруулах

ажлын хэсгийг байгуулан УСҮМ-ын талаар тусгай бүлэгт тусгасан хэдий ч хууль хэзээ батлагдах нь тодорхой бус хэвээр байна. Мөн хуулийн төслийг ЭШЭК-ийн нэмэлт протоколд бүрэн нийцүүлэх, УСҮМ-ын үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог хангах, УСҮМ-ын шийдвэр бүрэн хэрэгждэг байх чиглэлээр боловсронгуй болгох хэрэгцээ байна.

6. **Эрүүдэн шүүж олсон нотлох баримт нотлох чанараа алдах тухай:** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг дангаараа гэм буруутайг тогтоох шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй байх зарчмыг^v тусгасан нь тун чухал алхам хэдий ч эрүүдэн шүүж олж авсан нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй байхаар хатуу зохицуулаагүй.
7. **Ял шийтгэлээс мултрахтай тэмцэх:** Хуучин Эрүүгийн хуулийн 44.1 дүгээр зүйлийг цуцлах эсхүл өөрчлөн найруулах замаар хүний эрхийн зөрчил үйлдсэн этгээдийг ял шийтгэлээс мултрахаас сэргийлэх тухай Англи Улсын зөвлөмжийг^{vi} хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан. Шинэ Эрүүгийн хуулийн 4.6 дугаар зүйлийн 2 дох заалт дээрх үүрэг амлалттай нийцэхгүй байна.
8. **Албан хаагчдыг чадавхжуулах:** Манай улсын тухайд эрүүдэн шүүх асуудлаар хуульч, хууль сахиулагчдыг сургах чиглэлээр алхмууд авч хэрэгжүүлдэг ч бусад мэргэжилтэн, тухайлбал, эмнэлгийн мэргэжилтэн, сэтгэл зүйч, асрамж, халамжийн газрын ажилтнууд, цэргийн анги нэгтгэлийн алба хаагчдад энэ чиглэлийн сургалт зохион байгуулах ажил сул байна. Сүүлийн үед цэргийн анги нэгтгэл дээр цэрэг амь насаа алдах, эд эрхтэнээрээ хохирох хэрэг удаа дараа гарч байгаад ч анхаарал хандуулах шаардлагатай байна.^{vii}
9. **Мөрдөн шалгах нууц ажиллагаа:** Мөрдөн шалгах нууц ажиллагааны зөвшөөрлийг прокурор өгч байгаа нь учир дутагдалтай. Хүний халдашгүй байх эрхэд халдаж буй хэрэг тул зөвшөөрлийг шүүх өгөх нь зөв алхам юм. Мөн цагдан хорих байранд “мөрдөн шалгах нууц ажиллагаа” явуулахыг бүрмөсөн хориглохгүй бол эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд тодорхой ахиц гарахгүй. ХЗДХ-ийн Сайд Ц.Нямдоржийн нийтэд зарласан эрүүдэн шүүсэн хэрэг нь цагдан хорих байранд хийгдсэн гүйцэтгэх ажлын бичлэг юм.
10. **Цагдан хорих нийтлэг журмаас татгалзах:** Цагдан хорих нийтлэг журам үйлчилж байгаа болон цагдан хорихоос өөр таслан сэргийлэх арга хэмжээний хувилбар байхгүй хэвээр байна. Сүүлийн үед авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдуулан хүнийг шалгахдаа заавал цагдан хорих ёстой мэтээр олон нийтийг турхирах, таслан сэргийлэх арга хэмжээ авах хүсэлт гаргаагүй прокурорыг буруутгах, шийдвэр гаргах шүүгчид хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нөлөөлөх оролдлого ихээр гарч байна.
11. **Зөвлөмж**
 1. ЭШЭК-ийн хувь хүний, улс хоорондын гомдол мэдээллийн журмыг хүлээн зөвшөөрөх мэдэгдэл хүргүүлэх

2. Хараат бус мөрдөн шалгах албыг НҮБ-ын бүх шаардлагад нийцүүлэн нэн даруй байгуулах,^{viii} ингэхдээ тусгай субъектийн үйлдсэн бүх хэргийг бус зөвхөн эрүүдэн шүүх, зүй бус харьцаатай холбоотой мөрдөн шалгах эрхийг олгох замаар дагнасан, мэргэшсэн, цомхон байх боломжийг хангах.
3. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг ЭШЭК-ийн Нэмэлт протоколд бүрэн нийцүүлж, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангасан, хараат бусаар ажиллах, чиг үүргээ хэрэгжүүлэх хангалттай эрх хэмжээтэй, гаргасан шийдвэр, зөвлөмж нь хэрэгждэг байхаар зохицуулалтыг хуульд нарийвчлан тусгах
4. Эрүүгийн хуулийн 10, 11, 21 дүгээр зүйлд буй “эрүүдэн шүүх” үйлдлийг нэгтгэн, нэг гэмт хэрэг болгон тодорхойлж, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх” үйлдлийг гэмт хэрэгт тооцож, шинээр зүйлчлэх
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эрүүдэн шүүж олсон нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй байх, хууль бус тушаал, даалгавар биелүүлсэн нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөхгүй байх талаар холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах, цагдан хорих байранд “гүйцэтгэх ажил” явуулахыг хориглох, мөрдөн шалгах нууц ажиллагаатай холбоотой зөвшөөрлийг “шүүх” олгодог байх, зөвшөөрлийн хүрээ, хязгаарыг журмаар биш, хуулиар нарийвчлан зохицуулах
6. Хохирол барагдуулах үндэсний тогтолцоог нэн даруй бий болгох, эдийн бус хохирлыг үнэлэх, тооцох аргачлалыг нэн даруй батлан гаргах, үнэлгээ хийх мэргэжлийн байгууллагуудад эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлыг үнэлэх мэргэшсэн чиг үүрэг бүхий шинжээч эсхүл энэ чиглэлийн албыг байгуулж, ажилтнуудыг мэргэшүүлэн ажиллуулах замаар хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх
7. Сургалтын хөтөлбөрийг Истанбулын протоколд нийцүүлэн боловсруулах, хуульч, хууль сахиулагчдаас гадна эмнэлгийн мэргэжилтэн, бусад холбогдох ажилтнуудыг сургахад анхаарах, мөн сургалтын чанарт хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэх.

ⁱ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 45-р зүйл

ⁱⁱ Хүний эрхийн үндэсний комисс, Монгол Улс дах Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дах илтгэл, 2019 он, www.nhrcm.gov.mn, 77-85-р тал

ⁱⁱⁱ Хүний эрхийн үндэсний комисс, Монгол Улс дах Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дах илтгэл, 2019 он, www.nhrcm.gov.mn, 82-р тал

^{iv} Ц.Нямдорж: С.Зоригийн амь нас хохирсон хэрэгтэй холбогдуулан эрүүдэн шүүлт явагдсан.

Б.Содномдаржаа, Т.Чимгээ нарын ар гэрийнхнээс уучлал гуйж байна, <https://ikon.mn/n/1j0x> (2019.05.16)

^v Улсын их хурал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он, 16.3 дугаар зүйлийн 8.3 дах заалт

^{vi} НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ажлын хэсгийн хуралдааны тайлан, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэг I цикл, Англи Улс, Зөвлөмж 84.19

^{vii} Амиа алдсан цэрэг “Ээжээ намайг ирж аваачээ” гэж удаа дараа ар гэрлүүгээ ярьж байжээ.
<http://zarig.mn/bn2/>, Х.Нямбаатар: Энх цагт цэрэг эрс эрүүл мэнд, амь насаараа хохирохгүй тал дээр ямар бодлого барьж ажиллах вэ?<http://vip76.mn/content/59343>, Өрцийг нь цоо өшиглөсөн байсан гэв,
<https://news.mn/r/226784/>

^{viii} “Эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцаанаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар баримтлах бодлого”,ХЭФ, МХХ-ны хамтарсан бодлогын баримт бичиг, 2019 он